



**Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо**

ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН журам

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ
ӨДРӨЭС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ



МУССХ-НЫ ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

НЭГ. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЗОРИЛГО, ҮҮРЭГ

Шүүгчийн зөвлөл, түүний зорилго, үүрэг нь:

- 1.1 Шүүгчдийн зөвлөл нь (цаашид Зөвлөл гэх) МУССХ-ны дүрмийн 13.2 зүйлд заасан УЗ-ийн дэргэдэх шүүгчдээс бүрдсэн зөвлөл бөгөөд Удирдах Зөвлөл болон ЕНБД-ын өгсөн зөвшөөрлийн хүрээнд зөвхөн шүүгчдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бусад этгээдийн өмнө холбоог төлөөлж болно.
- 1.2 Зөвлөлийн гол зорилго нь шүүгчдийн үр чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон тэдний санал санаачлага, эрх ашгаа хамгаалуулах тухай саналуудыг Холбооны Удирдах Зөвлөл болон Их хуралд танилцуулж шийдвэрлүүлэх
- 1.3 Шүүгчдийн нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх болон тэднийг дотоод гадаадын сургалтанд оролцуулах боломжоор хангах
- 1.4 Шүүгчдэд холбооны дүрэм журам болон үр чадвар, ёс зүйн асуудлаар сургалт танилцуулга хийх
- 1.5 Зөвлөл нь бие даасан хуулийн этгээд биш бөгөөд Холбооны болон Зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

ХОЁР. ШҮҮГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1 Зөвлөл нь МУССХ-ны дүрэм, Удирдах зөвлөлөөс баталсан тогтоол шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 2.2 Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн ердийн олонхийн саналаар гаргах бөгөөд зөвлөлийн дарга саналын илүү эрх эдлэхгүй.
- 2.3 Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх аливаа асуудалд, тухайн асуудлаар цөөнх болсон гишүүдийн зарчмын зөрүүтэй байр суурийг заавал танилцуулна.
- 2.4 Зөвлөл нь тодорхой нэг асуудлаар шүүгчдийн дундаас ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.
- 2.5 Зөвлөл нь Нийт шүүгчдийн хурлаар хэлэлцүүлж, Удирдах зөвлөлөөр батлуулсан журам, үйл ажиллагааны үндсэн зарчимтай байна.



ГУРАВ. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

3.1 Зөвлөл нь нийт шүүгчдийн хурлаас сонгогдсон таван (5) хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.2 Зөвлөлийн гишүүд 60 нас хүртлээ нэг удаа улиран сонгогдож болох бөгөөд дээд тал нь найман (8) жил тасралтгүй Зөвлөлийн гишүүнээр ажиллаж болно.

3.3 Хэрэв өөрийн хүсэлтээр болон ёс зүйн дүрмийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн бол нөхөн сонгууль явуулна.

3.4 Зөвлөлийн гишүүн нь доорхи шаардлагыг хангасан байна:

(а) Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics), МУССХ-ны шүүгчийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх

(б) 18 нас хүрсэн

(в) Сэргээшийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх

(г) Зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас багагүй байна.

3.5 Зөвлөлийн бүрэлдэхүүн бүрэн ирцээр хуралдаж нууц санал хураалтаар олонхийн санал авсан гишүүнийг зөвлөлийн даргаар сонгоно.

3.6 Зөвлөлийн дарга нь Нийт шүүгчдийн хурлаас зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгосон сонгуулийн дүн болон Зөвлөлийн даргыг сонгосон тухай хурлын шийдвэрийг Удирдах зөвлөлд танилцуулж батлуулна.

3.7 Зөвлөлийн гишүүн зөвлөлд үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон тохиолдолд зөвлөлийн сонгуулийн дүнгээр эрэмблэгдсэн дарааллаар дараагийн нэр дэвшигчийг, тийм нэр дэвшигч байхгүй бол нөхөн сонгуулийг явуулж орны хүнийг тодруулна.

ДӨРӨВ. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

Зөвлөлийн гишүүн доорхи үүргийг хүлээнэ:

4.1 Энэхүү дүрмийн Нэг дүгээр хэсэгт заасан зөвлөлийн зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах

4.2 Холбооны болон Ёс зүйн дүрмийг чанд мөрдөж, Холбооны тэмцээний дүрмийн хэрэгжилтийг хангах, шударга өрсөлдөөн, сэргээшийн эсрэг дүрмийг биелэлтэнд хяналт тавих

4.3 Нийт шүүгчдийн болон Зөвлөлийн хуралд оролцох, Зөвлөлийн шийдвэрийг УЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх

4.4 Холбооны бусад зөвлөлүүдтэй нягт холбоотой ажиллаж, тэдний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг өгч хамтран ажиллах. Сургалт дадлагын үйл ажиллагааг явуулах.



4.5 Зөвлөлийн дүрмээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан гишүүнийг Ёс зүйн болон Хяналтын зөвлөлийн саналыг үндэслэн, УЗ-ийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно

ТАВ. НИЙТ ШҮҮГЧДИЙН БОЛОН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

5.1 Нийт шүүгчдийн хурлыг (цаашид Хурал гэх) жилд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд Удирдах зөвлөлтэй хэлэлцсний үндсэн дээр 14 хоногоос доошгүй хугацааны өмнө тов болон хэлэлцэх асуудлыг нийт шүүгчдэд мэдээлнэ.

5.2 Шүүгчдийн зөвлөлийн ээлжит бус хурал цахим хэлбэрээр хуралдаж болно.

5.3 Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг зохион байгуулах хүсэлтийг Удирдах зөвлөлд гарган хуралдуулж болно.

5.4 Хурлыг Зөвлөлийн дарга удирдах бөгөөд Зөвлөлийн сонгуульд жил Удирдах зөвлөлөөс хурал даргалагчийг санал болгож хурлыг даргалуулна.

5.5 Хурлыг зохион байгуулах ажилд ЕНБД болон Удирдах зөвлөлөөс томилогдсон гишүүн оролцоно.

5.6 Хурлын тэмдэглэл болон гаргасан шийдвэрийн хувийг ЕНБД хүргүүлнэ.

ЗУРГАА. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН СОНГУУЛЬ

6.1 Доорхи шаарлагыг хангасан шүүгчид, Нийт шүүгчдийн хуралд оролцох, зөвлөлийн сонгуульд санал өгөх, зөвлөлийн гишүүн байх эрхтэй.

(а) 18 нас хүрсэн

(б) Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics) эсвэл МУССХ-ны шүүгчийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх

(г) Зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас доошгүй байна.

6.2 Зөвлөлийн гишүүн байх шаардлагыг хангасан ямар ч шүүгч өөрийн болон бусад шүүгчийн нэрийг Зөвлөлийн сонгуульд нэр дэвшүүлж болно.

6.3 Санал хураахаас өмнө Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч бүр таван (5) минутаас ихгүй хугацаанд өөрийгөө танилцуулах эрхтэй.

6.4 Нийт шүүгчдийн хурлын төлөөлөгч бүр саналын нэг эрхтэй.

6.5 Сонгуулийг Удирдах зөвлөлөөс томилогдсон нэг, Хяналтын зөвлөлөөс томилогдсон нэг, ЕНБД гэсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна



6.6 Саналыг нууцаар хураах бөгөөд санал тооллогын дүнг комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан, Удирдах зөвлөлд танилцуулна

6.7 Хамгийн олон санал авсан таван (5) дэвшигчийг зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно

6.8 Санал тэнцсэн тохиолдолд тухайн нэр дэвшигчид дээр дахин санал хураалтыг зохион байгуулна

6.9 Зөвлөлийн гишүүд нэг удаа улиран сонгогдож болох бөгөөд дээд тал нь найман (8) жил тасралтгүй Зөвлөлийн гишүүнээр ажиллаж болно.

ДОЛОО. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

7.1 Шүүгчдийн зөвлөлийн дарга нь зөвлөлийн хурлыг зарлах, даргалах эрх үүрэгтэй.

7.2 Шүүгчдийн зөвлөлийн дарга нь МУССХ-ны Нэг дүгээр зэрэглэлийн тэмцээний Ерөнхий шүүгчээр ажиллах бөгөөд боломжгүй тохиолдолд мэдлэг, ур чадвар, түршлагатай хүнийг нийт шүүгчдийн дундаас сонгож томилох үүрэгтэй. Шүүгчдийн зөвлөлийн дарга эзгүй үед Шүүгчдийн зөвлөл энэхүү эрхийг эдэлнэ.

7.3 Шүүгчдийн зөвлөлийн дарга нь МУССХ-ны тэмцээний дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд ёс зүйн хороонд гомдол мэдээлэл гаргаж шийдвэрлүүлэх үүрэгтэй.

7.4 Холбооны бүх зэрэглэлийн тэмцээний Ерөнхий шүүгч болон шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилож арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

7.5 Нийт шүүгчдийн дунд сургалт, дадлагын ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол гадаадын өндөр мэрэгжлийн шүүгчдийг урьж арга зүйн сургалт авах ажлыг зохион байгуулах.

7.6 Шүүгчдийн зөвлөл нь болзол хангасан шүүчийг "Монгол улсын шүүгч"-д нэр дэвшүүлж Удирдах зөвлөлд уламжлах эрхтэй.

7.7 Шүүгчдийн зөвлөлийн дарга нь МУССХ-оос баталсан бүх төрлийн тэмцээн уралдаан болон шүүгчийн сургалтын төсөв санхүүг Удирдах зөвлөлөөр батлуулна.

7.8 Удирдах зөвлөлийн хуралд Зөвлөлийн тайлан хэлэлцүүлэх, зөвлөлийн гаргасан аливаа хүсэлтүүдийг танилцуулж шийдвэрлүүлэх.